



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ховд аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХОА-2025/003НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Ховд хот 2025 он	Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 70433061 Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас:70432545 Цахим хаяг: tsetsegsurena@audit.gov.mn Ахлах аудитор: Ц.Бадрал Утас:70432545 Цахим хаяг: badralts@audit.gov.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

2025.02.14

№ 02/34

танай

-ны №

-т

ХОВД АЙМГИЙН УС ЦАГ УУР,
ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН
ДАРГА А.ЭНХЗАЯА ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ховд аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Ховд аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд Цаг уур орчны шинжилгээний газар, Хар нуур ховд голын сав газрын захиргаа, Адапт төсөл, Чандмань сумын ОНХС, Мөнххайрхан сумын ОНХС-аас 258,209.4 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүйгээр, цахим дэлгүүрээс болон шууд худалдан авалтаар 108,543.1 мянган төгрөгийн хөрөнгийг худалдан авч санхүүгийн тайланд толилуулж, тодруулсан байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд төрийн албан хаагчийн цалин хөлс нэмэгдсэн, төрийн албан хаагчдад орон нутгийн нэмэгдлийг олгосонтой холбоотойгоор улсын төсвөөс 2,891,642.7 мянган төгрөг батлагдаж, 2,958,380.9 мянган төгрөгийг бүрдүүлэн зарцуулсан нь өмнөх оноос 62.7 хувиар өссөн байна. Тайлант онд төрийн үйлчилгээний албан хаагчдын цалингийн доод жишгийг 2 удаа даргын тушаалаар нэмэгдүүлэн тогтоосон байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд тус байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилт, 77 арга хэмжээ төлөвлөснөөс Цаг уур, орчны шинжилгээний газраас гүйцэтгэлийг 99.1 хувиар дүгнэсэн байна. Мөн усны салбар, хөдөө аж ахуйн салбар, цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагаа, байгаль орчны шинжилгээний лаборатори зэрэг үйл ажиллагааны чиглэл бүрээр 98 хувиас дээш дүгнүүлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.БОЛДБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>192,628,104.01</u>	<u>274,480,160.52</u>
33	АВЛАГА	703,511.82	6,255,218.15
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	703,511.82	6,255,218.15
34	УРЬДЧИЛГАА	-	500,000.00
3471	Урьдчилгаа тооцоо	-	500,000.00
34713	Цалингийн урьдчилгаа	-	500,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	191,924,592.19	267,724,942.37
351	Түүхий эд материал	179,676,962.76	223,997,306.37
35110	Тусгай зориулалттай материал	179,676,962.76	223,997,306.37
354	Хангамжийн материал	12,247,629.43	43,727,636.00
35410	Бичиг хэргийн материал	2,601,629.43	239,000.00
35420	Аж ахуйн материал	1,976,000.00	30,228,000.00
35430	Сэлбэг хэрэгсэл	4,170,000.00	-
35440	Түлш, шатах тослох материал	3,500,000.00	11,110,636.00
35470	Бусад хангамжийн материал	-	2,150,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,131,990,255.79</u>	<u>1,345,830,301.97</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,131,990,255.79	1,345,830,301.97
392	Биет хөрөнгө	874,131,455.77	1,086,199,001.93
39201	Барилга, байгууламж, орон сууц	676,362,674.00	779,883,074.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(118,993,625.08)	(155,421,944.86)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	512,479,391.78	614,372,152.49
39204	Хуримтлагдсан элэгдэл	(423,470,844.70)	(461,545,936.14)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	728,680,284.84	873,369,627.81
39206	Хуримтлагдсан элэгдэл	(522,036,082.86)	(597,726,888.94)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	31,884,728.88	46,734,728.88
39208	Хуримтлагдсан элэгдэл	(10,924,721.09)	(13,615,461.31)
39217	Ном	149,650.00	149,650.00
393	Биет бус хөрөнгө	257,858,800.02	259,631,300.04
39301	Программ хангамж	925,000.00	2,425,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(384,999.92)	(412,499.90)
39303	Бусад биет бус хөрөнгө	258,452,948.50	258,752,948.50
39304	Хуримтлагдсан элэгдэл	(1,134,148.56)	(1,134,148.56)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,324,618,359.80</u>	<u>1,620,310,462.49</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,324,618,359.80</u>	<u>1,620,310,462.49</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,324,618,359.80	1,620,310,462.49
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,221,235,417.47	1,221,235,417.47
51101	Өмч: - төрийн	1,221,235,417.47	1,221,235,417.47
512	Хуримтлагдсан үр дүн	(153,455,674.96)	142,236,427.73
51210	Өмнөх үеийн үр дүн	(153,455,674.96)	(153,455,674.96)

Ховд аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

51220	Тайлант үеийн үр дүн	-	295,692,102.69
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	256,838,617.29	256,838,617.29
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,324,618,359.80</u>	<u>1,620,310,462.49</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,448,320,916.11	4,115,228,778.34
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	179,806,116.11	332,885,307.34
120	Нийтлэг татварын бус орлого	179,806,116.11	332,885,307.34
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	179,806,116.11	332,885,307.34
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	179,806,116.11	332,885,307.34
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,268,514,800.00	3,782,343,471.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,263,697,800.00	3,634,577,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,263,697,800.00	3,634,577,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,817,000.00	147,766,271.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1,817,000.00	00.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,000,000.00	90,978,271.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	53,200,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	3,588,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,323,066,410.30	3,819,536,675.65
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,323,066,410.30	3,819,536,675.65
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,283,367,413.81	3,623,916,639.65
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,813,265,423.20	2,965,557,554.12
210101	Үндсэн цалин	1,654,424,149.74	1,713,621,509.02
210102	Нэмэгдэл	120,618,873.46	842,678,845.10
210103	Унаа хоолны хөнгөлөлт	38,222,400.00	281,723,500.00
210104	Урамшуулал	00.00	127,533,700.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	230,305,949.01	371,060,087.10
210201	Тэтгэврийн даатгал	155,527,644.76	254,393,539.93
210202	Тэтгэмжийн даатгал	18,177,945.59	29,853,095.66
210203	ҮОМШӨ-ний даатгал	14,542,356.42	14,896,848.03
210204	Ажилгүйдлийн даатгал	6,640,621.02	14,472,568.90
210205	Эрүүл мэндийн даатгал	35,417,381.22	57,444,034.58
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	56,315,717.86	53,944,125.00
210301	Гэрэл, цахилгаан	23,332,075.53	19,686,945.70
210302	Түлш, халаалт	30,541,612.33	31,264,179.30
210303	Цэвэр, бохир ус	2,442,030.00	2,993,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	17,808,672.65	23,955,337.45

Ховд аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210401	Бичиг хэрэг	3,574,860.00	2,539,800.00
210402	Тээвэр, шатахуун	10,347,217.00	17,579,923.45
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,983,845.65	2,810,114.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	902,750.00	825,500.00
210408	Бараа материал акталсны зардал	00.00	200,000.00
2105	Нормативт зардал	1,025,000.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,025,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	831,190.00	145,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	118,500.00	00.00
210604	Урсгал засвар	712,690.00	145,500.00
2107	Томилолт, зочны зардал	1,931,800.00	6,593,400.00
210702	Дотоод албан томилолт	1,931,800.00	6,593,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,697,713.00	13,597,650.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,713,219.00	12,228,800.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,479,400.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	235,000.00	472,850.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	216,375.00	622,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	00.00	33,600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	39,200.00	00.00
210807	Газрын төлбөр	14,519.00	240,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	156,185,948.09	189,062,985.98
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	79,515,050.00	36,143,453.48
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	7,075.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	76,670,898.09	152,912,457.50
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	39,698,996.49	195,620,036.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	36,907,500.00	190,938,318.55
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	53,200,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	36,907,500.00	137,738,318.55
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,791,496.49	4,681,717.45
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,791,496.49	4,681,717.45
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>124,715,389.84</u>	<u>295,692,102.69</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>124,715,389.84</u>	<u>295,692,102.69</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>2,268,514,800.00</u>	<u>3,782,343,471.00</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,268,514,800.00	3,782,343,471.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,263,697,800.00	3,634,577,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,263,697,800.00	3,634,577,200.00

Ховд аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,817,000.00	147,766,271.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1,817,000.00	00.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,000,000.00	90,978,271.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	53,200,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	3,588,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	2,173,922,990.00	3,674,100,371.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,173,922,990.00	3,674,100,371.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,134,223,993.51	3,478,480,335.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,817,452,100.00	2,958,380,997.55
210101	Үндсэн цалин	1,170,541,600.00	1,577,172,781.55
210102	Нэмэгдэл	339,342,400.00	826,702,316.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	156,400,000.00	385,419,900.00
210104	Урамшуулал	151,168,100.00	169,086,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	227,181,900.00	384,288,350.00
210201	Тэтгэврийн даатгал	154,483,300.00	268,622,550.00
210202	Тэтгэмжийн даатгал	18,174,800.00	28,916,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	14,539,800.00	14,458,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,635,000.00	14,458,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	36,349,000.00	57,832,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	54,504,891.86	56,173,325.00
210301	Гэрэл, цахилгаан	22,943,900.00	19,590,225.64
210302	Түлш, халаалт	29,118,961.86	33,590,099.36
210303	Цэвэр, бохир ус	2,442,030.00	2,993,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	21,266,433.65	25,053,637.45
210401	Бичиг хэрэг	2,790,100.00	2,642,800.00
210402	Тээвэр, шатахуун	12,269,000.00	18,490,623.45
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,658,233.65	2,810,114.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,549,100.00	1,110,100.00
2105	Нормативт зардал	1,175,000.00	171,700.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,175,000.00	171,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,852,040.00	732,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,276,500.00	369,300.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	562,750.00	64,300.00
210604	Урсгал засвар	3,012,790.00	298,800.00
2107	Томилолт, зочны зардал	1,931,800.00	6,593,400.00
210701	Гадаад албан томилолт	00.00	00.00
210702	Дотоод албан томилолт	1,931,800.00	6,593,400.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	00.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,156,728.00	46,994,950.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,101,317.00	45,626,100.00

Ховд аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,479,400.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	305,917.00	472,850.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	216,375.00	622,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	00.00	33,600.00
210807	Газрын төлбөр	14,519.00	240,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	39,200.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	703,100.00	91,575.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	703,100.00	91,575.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	39,698,996.49	195,620,036.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	36,907,500.00	190,938,318.55
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	53,200,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	36,907,500.00	137,738,318.55
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,791,496.49	4,681,717.45
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,791,496.49	4,681,717.45
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>94,591,810.00</u>	<u>108,243,100.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	94,591,810.00	108,243,100.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	94,591,810.00	108,243,100.00
2200	Дотоод эх үүсвэрээр	94,591,810.00	108,243,100.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	94,591,810.00	108,243,100.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-94,591,810.00</u>	<u>-108,243,100.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,221,235,417.47	256,838,617.29	-153,455,674.96	1,324,618,359.80
D01	2024 оны 01-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,221,235,417.47	256,838,617.29	-153,455,674.96	1,324,618,359.80
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,221,235,417.47	256,838,617.29	-153,455,674.96	1,324,618,359.80
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00

D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	295,692,102.69	295,692,102.69
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,221,235,417.47	256,838,617.29	142,236,427.73	1,620,310,462.49

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,634,577,200.00	3,629,895,482.55
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,634,577,200.00	3,629,895,482.55
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,496,785,700.00	3,492,157,164.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,891,642,700.00	2,891,642,700.00
210101	Үндсэн цалин	1,523,965,100.00	1,523,965,100.00
210102	Нэмэгдэл	813,171,700.00	813,171,700.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	385,419,900.00	385,419,900.00
210104	Урамшуулал	169,086,000.00	169,086,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	373,955,500.00	373,955,500.00
210201	Тэтгэврийн даатгал	258,289,700.00	258,289,700.00
210202	Тэтгэмжийн даатгал	28,916,500.00	28,916,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	14,458,200.00	14,458,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	14,458,300.00	14,458,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	57,832,800.00	57,832,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	59,574,000.00	56,173,325.00
210301	Гэрэл, цахилгаан	22,943,900.00	19,590,225.64
210302	Түлш, халаалт	33,637,100.00	33,590,099.36
210303	Цэвэр, бохир ус	2,993,000.00	2,993,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	11,268,700.00	10,775,514.00
210401	Бичиг хэрэг	1,902,200.00	1,872,800.00
210402	Тээвэр, шатахуун	5,333,500.00	5,333,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,273,900.00	2,810,114.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	759,100.00	759,100.00
2105	Нормативт зардал	171,700.00	171,700.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	171,700.00	171,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	108,975,500.00	108,975,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	108,612,400.00	108,612,400.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	64,300.00	64,300.00
210604	Урсгал засвар	298,800.00	298,800.00
2107	Томилолт, зочны зардал	3,376,400.00	3,376,400.00
210702	Дотоод албан томилолт	3,376,400.00	3,376,400.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	47,720,100.00	46,994,950.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	45,763,300.00	45,626,100.00
210803	Даатгалын үйлчилгээ	592,800.00	472,850.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	622,400.00	622,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	33,600.00	33,600.00
210807	Газрын төлбөр	708,000.00	240,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	101,100.00	91,575.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	101,100.00	91,575.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	137,791,500.00	137,738,318.55
2132	Бусад урсгал шилжүүлэг	137,791,500.00	137,738,318.55
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	137,791,500.00	137,738,318.55
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,634,577,200.00	3,629,895,482.55
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,634,577,200.00	3,629,895,482.55
131001	Улсын төсвөөс санхүүжих	3,634,577,200.00	3,629,895,482.55

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		147,766,271.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		147,766,271.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,817,000.00	94,566,271.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		66,738,297.55
210101	Үндсэн цалин		53,207,681.55
210102	Нэмэгдэл		13,530,616.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		10,332,850.00
210201	Тэтгэврийн даатгал		10,332,850.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,967,000.00	14,278,123.45
210401	Бичиг хэрэг	282,000.00	770,000.00
210402	Тээвэр, шатахуун	3,000,000.00	13,157,123.45
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	685,000.00	351,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	300,000.00	00.00
210604	Урсгал засвар	300,000.00	00.00
2107	Томилолт, зочны зардал	550,000.00	3,217,000.00
210702	Дотоод албан томилолт	550,000.00	3,217,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	53,200,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		53,200,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		53,200,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,817,000.00	147,766,271.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,817,000.00	147,766,271.00

131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		90,978,271.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,000,000.00	53,200,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,817,000.00	3,588,000.00

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 4,195.3 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 1,210.0 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа¹-г залруулж, баталгаажуулав. Үүнд:

- Үр дүнгийн тайланд зардал илүү тусгасан - 972.2 мянган төгрөг
- Авлага илүү бүртгэсэн – 237.8 мянган төгрөг байна.

Залруулагдаагүй нийт 2,985.3 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 2,985.3 мянган төгрөгийн 2 зөрчил² илэрснээс, 2,985.3 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгсөн.

3.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

3.1.1 Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Шилэн дансны цахим хуудсанд байршуулах мэдээллээс хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.5, 6.4.8-д заасныг түүвэрлэн авч үзэхэд нийт 171 мэдээлэл байршуулахаас жилийн эцсийн санхүүгийн тайлан, хандив тусламжийн орлого, хандив тусламжийн зарцуулалтын тайлан, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг мэдээлэх хугацаа болоогүйтэй холбоотой 4 мэдээллийг байршуулаагүй, 167 мэдээллийг хугацаанд нь байршуулсан харагдаж байгаа боловч Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл, өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогоос давсан хэсгийг урамшуулалд зарцуулсан тайлан, төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарыг оруулаагүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.6-д "хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээг тендер зарлаж, сонгон шалгаруулсан бол шалгаруулалтын ерөнхий мэдээлэл"-ийг тухай бүр, 6.3.4-д "өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогын давсан хэсгийг урамшуулалд зарцуулсан бол зориулалтыг заасан байх;" гэснийг дараа оны 4 сарын 25-ны дотор, 6.1.6-д "төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар"-ыг улирал бүр мэдээлнэ гэсэнтэй нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг бүрэн, үнэн зөв мэдээлэх.

3.1.2 Дотоод хяналт, хариуцлагатай холбоотой асуудал

Илрүүлэлт: 2024 оны эхний улиралд тус байгууллагын албан хаагчид ТҮ ангиллаар цалинжиж байсан бөгөөд доод жишгийг 20 хувиар нэмэгдүүлэн цалинжуулж байснаа 4 дүгээр сараас ТҮМ ангилалд шилжихдээ зарим албан хаагчдын цалин хөлс буурсан бөгөөд

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

ажлын ачааллыг харгалзах байдлаар ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдэлд 2,985.3 мянган төгрөг олгож байгаа нь Хөдөлмөрийн тухай хуулийн 56.1-д “Ажил олгогч нь ажилтантай тохиролцсоноор ажил хослон гүйцэтгүүлэх, эзгүй байгаа ажилтны үүргийг түр орлон гүйцэтгүүлэх, ажилтны ажлын цагт багтаан өөр ажил, албан тушаал хавсран гүйцэтгүүлэх, ажлын ачааллыг нэмэгдүүлэх хэлбэрээр ажиллуулж болно.”, Засгийн газрын 2023 оны 240 дүгээр тогтоолын 7 дугаар хавсралтаар баталсан “төрийн үйлчилгээний мэргэжлийн бусад байгууллагын албан тушаалын зэрэглэл, түүнд хамаарах албан тушаалын жагсаалт”-тай нийцээгүй.

Өгсөн зөвлөмж: Албан тушаалын тодорхойлолтод заасан үүргээ гүйцэтгэж байгаа албан хаагчид албан тушаалын заасан цалин хөлс олгох.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
							Залруулсан		Залруулаагүй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үр дүнгийн тайланд зардал илүү тусгасан, авлага илүү бүртгэсэн.	1	1,210.0			1	1,210.0	1	1,210.0		
Дүн	1	1,210.0			1	1,210.0	1	1,210.0		

4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдаа, зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
2024 оны эхний улиралд тус байгууллагын албан хаагчид ТҮ ангиллаар цалинжиж байсан бөгөөд доод жишгийг 20 хувиар нэмэгдүүлэн цалинжуулж байснаа 4 дүгээр сараас ТҮМ ангилалд шилжихдээ зарим албан хаагчийн цалин хөлс буурсан бөгөөд ажлын ачааллыг харгалзах байдлаар ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдэл олгож байна.	1	2,985.3					1	2,985.3
Дүн	1	2,985.3					1	2,985.3

4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								

Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл, өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогоос давсан хэсгийг урамшуулалд зарцуулсан тайлан, төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарыг оруулаагүй байна.	1	-	-	-	1	-
--	---	---	---	---	---	---

5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1			1			